

**ХАРИЛЦАХ ДАНС НЭЭЖ, ТӨЛБӨР ТООЦООНЫ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ
ЕРӨНХИЙ ГЭРЭЭ**

20... оны ...-р сарын ...-ны өдөр Дугаар Улаанбаатар хот

Энэхүү ГЭРЭЭГ /цаашид "Гэрээ" гэх-г Монгол Улсын Иргэний хууль, Банкны тухай хуулийн 10 дугаар зүйл, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны хууль"-ийн 3 дугаар бүлгийг тус тус үндэслэн,
Нэг талаас /регистрийн 2637545 тоот дугаартай/ УЛААНБААТАР ХОТЫН БАНК /цаашид

"Банк" гэх/, нөгөө талаас тоот Улсын бүртгэлийн гэрчилгээтэй,
..... тоот регистрийн дугаартай,

..... /цаашид "Харилцагч" гэх хамт нь "Талууд" гэх/ нар дор дурьдсан нөхцлүүдийн талаар харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Гэрээний ерөнхий нөхцөл

- 1.1. Энэхүү гэрээ нь Банк Харилцагчийн хүсэлтийг үндэслэн тогтоосон журмын дагуу харилцах данс /цаашид "данс" гэх/ нээх, төлбөр тооцооны үйлчилгээ /бэлэн болон бэлэн бус хэлбэрээр хийх гүйлгээ/ үзүүлэх, тус Харилцагчийн дансны тогтвортой үлдэгдэл хүү төлөх, Харилцагч өөрийн дансны үлдэгдлийг "Банкны үйлчилгээний хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөл"-д заасан хэмжээгээр тогтмол байлгах, төлбөр тооцоо гүйцэтгэх үйлчилгээний хөлсийг Банканд төлөхтэй холбогдон үүсэх харилцаа болон Талуудын эрх, үүрэг, хариуцлага зэргийг зохицуулахад оршино.
- 1.2. Банкнаас үзүүлж буй эзэл, мөнгөн хадгаламжийн үйлчилгээ, аккредитив, инкассан төлбөр тооцоотой холбогдох харилцааг тусгай гэрээгээр зохицуулна.
- 1.3. "Банкны үйлчилгээний хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөл" нь Гэрээний салшгүй хэсэг байх бөгөөд банк өөрийн санаачлагаар түүнд нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй болно.
- 1.4. Энэхүү гэрээнд хэрэглэсэн дараах нэр томбоогоор дурьдсан утгаар ойлогоно. Үүнд:
 - 1.4.1. "Нууц үг" гэж Банкны үйлчилгээ авахад ирсэн Харилцагч, түүний бүрдүүлсэн төлбөр тооцооны баримт сэжигтэй байна гэж Банк үзвэл Харилцагч, түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд мөн эсэхийг баталгаажуулах, Харилцагчийн төлбөр тооцооны аюулгүй байдал, нууцлалыг хангах зорилгоор Гэрээнд заасны дагуу хэрэглэгдэж буй Харилцагчийн санал болгосон тоон болон үсгэн илэрхийллийг;
 - 1.4.2. "Нууц үгний асуулт" гэж Харилцагч Нууц үгээр мартсан тохиолдолд Банк сануулах үүднээс асуух Харилцагчийн санал болгосон асуултыг;
 - 1.4.3. "Онлайн үйлчилгээ" гэж Харилцагч Харилцах дансаа Улаанбаатар хотын банкны аль салбар, нэгжид нээлгэсэнээ үл хамааран тус банкны дурын салбараас харилцах дансандаа хандан төлбөр тооцооны үйлчилгээ /бэлэн болон бэлэн бус хэлбэрээр хийх гүйлгээ/ авахыг хэлнэ.
 - 1.4.4. "Интернэт банкны үйлчилгээ" гэж www.ubcbank.mn/ebank хаягаар холбогдож, банкны дараах үйлчилгээг авахыг хэлнэ. Үүнд:
 - а. Дансны лавлагаа, мэдээлэл харах
 - б. Бэлэн бус төлбөр тооцоо хийх
 - в. Хадгаламжийн хугацаа сунгах
 - г. Банк руу захидал илгээх болон банкнаас захидал, мэдээлэл хүлээн авах.
 - 1.4.5. "Мобайл банкны үйлчилгээ" гэж гар утсаараа дамжуулан банкны дараах үйлчилгээг авахыг хэлнэ. Үүнд:
 - а. Гүйлгээний лавлагаа авах, хуульга харах
 - б. Бэлэн бус төлбөр тооцоо хийх
 - 1.4.6. "Давагдашгүй хүчин зүйл" гэж үер, гал, газар хөдлөлт болон бусад байгалийн гамшиг цахилгаан болон телефон утасны шугам тасрах, компьютерийн болон сүлжээний ямар нэгэн вирусын халдлага зэргийг хэлнэ.

Хоёр. Гэрээний хугацаа

- 2.1. Энэхүү Гэрээг 20 ... оны ... дугаар сарын-ны өдрөөс эхлэн харилцах данс хаагдах өдрийг хүртэл хугацаатайгаар байгуулав.

Гурав. Данс нээх, хаах үйл ажиллагаа

- 3.1. Банк Харилцагчийн ирүүлсэн дараах баримт бичгийг үндэслэн данс нээнэ. Үүнд:
 - 3.1.1. Данс нээлгүүлэхийг хүссэн бичгээр гаргасан хүсэлт;
 - 3.1.2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар;
 - 3.1.3. Дансанд дахь мөнгөн хөрөнгийг захиран зарцуулах эрх бүхий этгээдийн овог, нэр, албан тушаал, төлбөр тооцооны баримтад зурах гарын үсгийн маяг, тамга, тэмдгийн загвар. Гарын үсгийн маяг, тамга, тэмдгийн загварыг нотариатаар баталгаажуулсан байна;
 - 3.1.4. Монгол улсын татварын албаны мэдэгдэл
- 3.2. Банк дараах тохиолдолд Гэрээг цуцалж Дансыг хаана. Үүнд:
 - 3.2.1. Харилцагчийн бичгээр гаргасан хүсэлтийн дагуу;
 - 3.2.2. Гэрээний 3.1 дэх хэсэгт заасан баримт бичгүүд хууль бус, хуурамч болох нь тогтоогдсон;
 - 3.2.3. Дансандаа заавал байлгах үлдэгдлийн доод хэмжээг 2 жилээс дээш хугацаагаар тогтмол байршуулаагүй;
 - 3.2.4. Хуульд заасан бусад тохиолдолд.

Дөрөв. Банкны эрх, үүрэг

4.1. Банкны үүрэг:

- 4.1.1. Банк нь Харилцагчид данс нээж, төлбөр тооцооны үйлчилгээг гүйцэтгэн, дансны сарын дундаж үлдэгдэлд 4.1.3-т заасны дагуу хүү бодож, харилцах дансанд олгоно.
- 4.1.2. Харилцагчаас төлбөр тооцооны баримт хүлээн авсан өдрийнхөө гүйлгээний цаг /9.00-17.30/-т багтаан төлбөр тооцоог гүйцэтгэх бөгөөд харин 15.30 цагаас ойт хүлээн авсан банк хооронд шилжих төлбөр тооцоог дараагийн ажлын өдрийн 10.00 цагт гүйцэтгэх.
- 4.1.3. Банк Харилцагчийн дансны сарын тогтвортой дундаж үлдэгдэлд доорх хүүг тооцно. Үүнд:

Харилцах дансны сарын дундаж үлдэгдэл (төгрөгөөр/.....)	Сарын дундаж үлдэгдэлд төлөх жилийн хүү

- 4.1.4. Төлбөр тооцооны баримтын бүрдүүлбэрийг шалган, үнэн, зөв, бүрэн тохиолдолд Дансны үлдэгдэл /заавал байлгах үлдэгдэлд илүү гарсан дүн/-д нь багтаан төлбөр тооцоог түргэн шуурхай, саадгүй /хүсэн авсан дарааллын дагуу/ гүйцэтгэх.
- 4.1.5. Харилцагчийн мэдээллийн нууцлалыг чанд халгалж, Харилцагч зөвшөөрсөн эсвэл хуульд зааснаас бусад тохиолдолд бусад гаргаж өгөхгүй, задлахгүй, ашиглуулахгүй байх.
- 4.1.6. Харилцагчийн хүсэлтээр Дансны хуульга болон гүйлгээ, үлдэгдлийн талаарх мэдээллийг цаг тухайд нь гаргаж өгөх;
- 4.1.7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэчийн мэдэгдэл, татварын албаны мэдэгдэх хуудас болон үл маргалдах журмаар төлөх тухай Харилцагчийн гарын үсэг бүхий хүчин төгөлдөр гэрээг үндэслэн хийх гүйлгээгээс бусад тохиолдолд Харилцагчийн зөвшөөрөлгүйгээр Данснаас нь зарлагын гүйлгээ хийхгүй байх.
- 4.1.8. Харилцагчийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байх.
- 4.1.9. Банк өөрийн алдаатай хийсэн мөнгөн төлбөрийн гүйлгээг залруулж, Харилцагчийг хохиролгүй болгох, Банк өөрийн буруугаас Харилцагчид учруулсан хохирлыг нөхөн төлөх;

- 4.1.10. "Банкны үйлчилгээний хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөл"-өө Харилцагчид таницуулах;
- 4.1.11. Хууль, Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх.

4.2. Банкны эрх:

- 4.2.1. Төлбөр тооцооны үйлчилгээний хөлсийг тухай бүр "Банкны үйлчилгээний хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөл"-д заасны дагуу тооцон Данснаас суутган авах;
- 4.2.2. Харилцагчийн ирүүлсэн баримт бичиг Гэрээний 3.1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангаагүй бол Данс нэхээс татгалзах;
- 4.2.3. "Банкны үйлчилгээний хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөл", Гэрээний 4.1.3-т заасан хүүгийн хэмжээг санхүү, мөнгөний зах зээл, үйлчилгээний хүүрээ ачаалал, Харилцагчийн эрэлт хэрэгцээг харгалзан Банк бие даан өөрчлөх. Ийнхүү өөрчлөхдөө Харилцагчид ажлын 3 хоногийн өмнө мэдэгдэнэ.
- 4.2.4. Гэрээний 3.2 дахь хэсэгт заасны дагуу Гэрээг цуцалж, Харилцагчийн Дансыг хаах;
- 4.2.5. Харилцагчийн буруугаас мөнгөн төлбөрийн гүйлгээ буруу хийгдсэн тохиолдолд залруулах үүрэг хүлээхгүй байх;
- 4.2.6. Банк Харилцагчийг Онлайн үйлчилгээгээр төлбөр тооцоо хийх, Утсаар гүйлгээний талаар мэдээлэл авах үед эсвэл түүний бүрдүүлсэн Төлбөр тооцооны баримт сэжигтэй байна гэж үзвэл Харилцагч, түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд мөн эсэхийг баталгаажуулах, Харилцагчийн төлбөр тооцооны аюулгүй байдал, нууцлалыг хангах зорилгоор түүнээс Гэрээний 1.4.2-д заасан Нууц үгний асуултыг асууна. Хэрэв Харилцагч аливаа шалтгаанаар 3 удаа дараалан Нууц үгний хэж чадаагүй тохиолдолд Банк мэдээлэл өгөх, гүйлгээ хийхээс татгалзах бөгөөд үүнээс шалтгаалан Харилцагч, гуравдагч этгээдэд учирсан аливаа хохирол, зардал, банкны Банк хариуцахгүй байх;
- 4.2.7. Хууль, Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Харилцагчаас шаардах;
- 4.2.8. Хуульд заасан бусад эрх.

Тав. Харилцагчийн эрх, үүрэг

5.1. Харилцагчийн үүрэг:

- 5.1.1. "Банкны үйлчилгээний хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөл"-тэй танилцсаны үндсэн дээр Гэрээнд заасан нөхцөл, журмын дагуу данс нээлгүүлж, төлбөр тооцооны үйлчилгээ авах;
- 5.1.2. Төлбөр тооцооны баримтын бүрдүүлбэрийг зөв, алдаагүй бүрдүүлж өгөх;
- 5.1.3. Дансанд заавал байлгах үлдэгдлийг тогтмол байршуулах;
- 5.1.4. Банкнаас тогтоосон төлбөр тооцоо гүйцэтгэх үйлчилгээний хөлсийг төлөх;
- 5.1.5. Банкны нэмэлт үйлчилгээ болох Онлайн, Интернэт, Мобайл банкны үйлчилгээг авах хүсэлтэй бол үйлчилгээний зааврыг баримтлан ажиллах;
- 5.1.6. Дансны хуульга нь зөрүүтэй тохиолдолд энэ тухай Банкнд яаралтай мэдэгдэх;
- 5.1.7. Албан ёсны нэр, данснаас мөнгөн хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий этгээд, тамга тэмдгийн загвар өөрчлөгдөх тохиолдолд Банкнд 1-ээс доошгүй хоногийн өмнө урьдчилан мэдэгдэж, Харилцагчийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хүсэлтээр Гэрээний 3.1.3 дахь заалтад заасан баримтуудыг шинэчилж өгөх;
- 5.1.8. Гэрээний 5.1.2, 5.1.7, 5.1.9 дахь заалтуудад заасан үүргээ биелүүлэхгүйгээр учирсан аливаа хохирлыг бүрэн хариуцах;
- 5.1.9. Гэрээний 5.2.2 дахь заалтад заасны дагуу төлбөрийн даалгавар цуцлах тохиолдолд Харилцагч нь Банкны холбогдох ажилтанд нэн даруй мэдэгдэх бөгөөд хэрэв нэгэнт төлбөр тооцоог гүйцэтгэсэн байгаа тохиолдолд төлбөрийн даалгавраа цуцлахыг шаардсан эрхгүй;
- 5.1.10. Нууц үгээр мартахгүй, гуравдагч этгээдэд залруулахгүй байж, Банкны шаардсан үед Нууц үгээ хэлж өөрийн эрхийг баталгаажуулах;
- 5.1.11. Бусад харилцагчийн талаарх мэдээллийг Банкнаас шаардахгүй байх;
- 5.1.12. Харилцах данснаасаа 50 саяас дээш (төгрөг/ ам.доллар) бэлнээр авах бол Банкнд 1 өдрийн өмнө мэдэгдэнэ. Ийнхүү мэдэгдэхгүйгээр болж үүсэх хариуцлагыг Банк хүлээхгүй.
- 5.1.13. Хууль, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх.

5.2. Харилцагчийн эрх:

- 5.2.1. Төлбөр тооцоогоо Банкаар дамжуулан түргэн шуурхай гүйцэтгүүлэх;
- 5.2.2. Төлбөрийн гүйлгээг гүйцэтгэхээс өмнө төлбөрийн даалгавраа цуцлах;
- 5.2.3. Банкны үзүүлж буй үйлчилгээний талаар болон "Банкны үйлчилгээний хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөл"-тэй холбогдолтой асуудлуудаар санал, хүсэлт гаргах;
- 5.2.4. Харилцагч нь тогтоосон журмын дагуу Банкнаас үзүүлж буй бүх төрлийн үйлчилгээ авах;
- 5.2.5. Дансны үлдэгдэл, гүйлгээний талаарх мэдээллээ Банкнаас гаргуулан авах.
- 5.2.6. Өөрийн хүсэлтээр нэмэлт үйлчилгээг авах хүсэлтээ Гэрээний хугацаанаас өмнө цуцлах эрхтэй.
- 5.2.7. Банкны буруутай үйл ажиллагааны улмаас учирсан хохирлоо Банкаар нөхөн төлүүлэх;
 - 5.2.7.1. Энэхүү гэрээнд заасан хүүг орлогод авах бөгөөд өөрийн дансанд хийгдсэн орлого, зарлагын гүйлгээ, үлдэгдэл хүүгийн бодолтыг Биеэр ирж болон утсаар шалгах;
- 5.2.8. Онлайн үйлчилгээ, Интернэт банк болон Мобайл банкны үйлчилгээний нэмэлт талбарыг бөглөсөнөөр эдгээр үйлчилгээг авах эрхтэй болно.
- 5.2.9. Хэрэв Банкний гэрээнд заасан үүргээ биелүүлэхгүй байна гэж үзвэл Банкны удирдах дээд байгууллага болон шүүхэд гомдол гаргах эрхтэй.
- 5.2.10. Дансны нууц үгээ өөрчлөх. Харилцагч нууц үгээ өөрчлөхдөө Банканд дээр биеэр ирж бичгээр хүсэлт гаргана.
- 5.2.11. Хууль, Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Банкнаас шаардах;
- 5.2.12. Хуульд заасан бусад эрх.

Зургаа. Хариуцлага

- 6.1. Харилцагч төлбөр тооцооны баримтыг хуурамчаар үйлдэх, залилах, хууран мэхлэх, Гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчих замаар Банканд хохирол, зардал учруулсан бол учруулсан аливаа хохирол, зардалаа Дансан дахь хөрөнгө, бусад арилжааны банк дахь дансны хөрөнгө болон бусад хөрөнгө /хөдлөх, үл хөдлөх/-нөөсөө үл маргалдах журмаар төлнө. Энэ тохиолдолд Харилцагч тусгайлан зөвшөөрөл өгөх шаардлагыг бөгөөд Гэрээ нь захиран зарцуулах зөвшөөрлийг бүрэн илэрхийлэхийг Талууд тохиролцов.
- 6.2. Харилцагчийн өөрийн (төлбөр тооцооны баримтын бүрдүүлбэр дутуу, нууц үгээр мартсан, бусдад алдсан, бусад үйлдэл, үйл ажиллагаа) болон бусад банкны буруутай үйл ажиллагаанаас болж Харилцагчийн төлбөр тооцоо саатсан, Харилцагчийн гүйлгээний талаар мэдээлэл алдагдсан, түүнд хохирол, зардал учирснаас үүдэн гаргах хариуцлагыг Банк хүлээхгүй.
- 6.3. Талууд Гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөнөөс нөгөө талдаа учирсан аливаа зардал, хохирлыг бүрэн хариуцаж барагдуулна.
- 6.4. Интернэт болон Мобайл банк үйлчилгээг ашиглаж байгаа тохиолдолд сүлжээний саатлаас болж хийгдэхгүй шилжүүлэгт банк ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.
- 6.5. Гэнэтгийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүдэлтэй харилцагчид учирсан хохирлыг банк хариуцахгүй.

Долоо. Маргаан шийдвэрлэх

- 7.1. Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг Талууд зөвшилцөх аргаар шийдвэрлэнэ.
- 7.2. Хэрэв Гэрээний 7.1 дэх хэсэгт заасан аргаар маргаан, зөрөлдөөнийг шийдвэрлэж чадахгүй бол Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

Найм. Бусад зүйл

- 8.1. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Талууд харилцан тохиролцож, нэмэлт гэрээ байгуулсаны үндсэн дээр шийдвэрлэнэ.

Гэрээ байгуулсан:

Харилцагчийг төлөөлж:

Банкныг төлөөлж:

.....